**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төлбөрийн системийн шинэчлэл төслийн 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөр дуусвар болсон хаалтын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СНАГ-2024/52/НА-СТА-ТХН

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Улаанбаатар хот<br>2024 он | Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг<br>Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: П.Чанцалдулам<br>Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn<br><br>Аудитор: Д.Болормаа<br>Утас: 261628 Цахим хаяг: bolormaad@audit.gov.mn<br><br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954<br>Цахим хаяг: dabg.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.20 № 07/241
танай ____________-ны № ____________-т

ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ШИНЭЧЛЭЛ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ Л.БАТТӨГӨЛДӨР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төлбөрийн системийн шинэчлэл төслийн 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөр дуусвар болсон хаалтын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төлбөрийн системийн шинэчлэл төслийн 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөр дуусвар болсон хаалтын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монголбанкны ерөнхийлөгчийн 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн А-127 тоот тушаалаар "Төслийн хөрөнгийг хүлээн авах комисс" байгуулагдаж төслийн үйл ажиллагаанд ашиглаж байсан 108,509.5 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, компьютер тоног төхөөрөмжийг Монголбанкны Тамгын газарт 2023 оны 10 дугаар 19-ний өдөр акт үйлдэн хүлээлгэж өгсөн.

Төслийн үйл ажиллагаа дууссан тул ашиглаагүй санхүүжилтийн үлдэгдэл 207,282.9 мянган төгрөгийг Азийн хөгжлийн банканд, 50,870.5 мянган төгрөгийг Монголбанканд тус тус шилжүүлэн 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр төслийн харилцах данс бүрэн хаагдсанаар 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөр дуусвар болсон хаалтын санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Төслийг хэрэгжүүлэх нийт хугацаанд буюу 2016-2023 онд 5 бүрэлдэхүүн хэсгийн 22 чиглэлд нийт 20.0 сая ам.долларыг гадаад зээлийн санхүүжилтээс авахаар төлөвлөснөөс төслийн үйл ажиллагааны нийт хэрэгжилт 100.0 хувь, санхүүжилтийн зарцуулалт 19.7 сая ам.доллар буюу 56,334,196.7 мянган төгрөг байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 1 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 10 дугаар сарын 30-нs өдрөөр дуусвар болсон хаалтын тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **29,317,739,885.70** | **-** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **3,247,534,185.98** | **-** |
| 312 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **3,247,534,185.98** | **-** |
| 3122 | **Гадаад валют** | **3,247,534,85.98** | **-** |
| 31222 | Монгол банк дахь харилцах | 3,197,803,882.65 | - |
| 31223 | Арилжааны банк дахь харилцах | 49,730,303.33 | - |
| 34 | **УРЬДЧИЛГАА** | **26,070,205,699.72** | **-** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 26,070,205,699.72 | - |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **18,584,715.33** | **-** |
| 392 | **Үндсэн хөрөнгө** | **18,584,715.33** | **-** |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж (компьютер) | 72,898,909.96 | - |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (66,844,347.43) | - |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 29,110,616.27 | - |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (16,580,463.47) | - |
| 393 | **Биет бус хөрөнгө** | **-** | **-** |
| 39301 | Программ хангамж | 6,500,000.00 | - |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (6,500,000.00) | - |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **29,336,324,601.03** | **-** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **7,192,301,156.98** | **-** |
| 41 | **Богино хугацаат өр төлбөр** | **7,192,301,156.98** | **-** |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | 7,106,254,235.34 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 27,772,650.00 | - |
| 41362 | Хувь хүмүүст өгөх өглөг | 58,274,271.64 | - |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **22,144,023,444.05** | **-** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | | |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 22,144,023,444.05 | - |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 18,541,625,448.65 | 22,144,023,444.05 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 3,602,397,995.40 | (22,144,023,444.05) |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **29,336,324,601.03** | **-** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөр дуусвар болсон хаалтын тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **14,303,535,766.52** | **4,306,930,919.75** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **14,303,535,766.52** | **4,306,930,919.75** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | **14,303,535,766.52** | **4,306,930,919.75** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 57,077,250.00 | 153,450,000.00 |
| 1200044 | Гадаад эх үүсвэрээс санхүүжих | 13,013,751,700.61 | 4,153,480,919.75 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,231,806,815.91 | - |
| 120009 | Бусад орлого | 900,000.00 | - |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,225,537,753.96** | **299,973,549.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,225,537,753.96** | **299,973,549.00** |
| 210 | **Бараа, ажил үйлчилгээний зардал** | **1,225,537,753.96** | **299,973,549.00** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **346,890,000.00** | **136,400,000.00** |
| 210101 | Үндсэн цалин | 346,890,000.00 | 136,400,000.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **43,361,250.00** | **17,050,000.00** |
| 210201 | Нийгмийн даатгалын шимтгэл | 43,361,250.00 | 17,050,000.00 |
| 2103 | **Байр ашиглалтын тогтмол зардал** | **13,716,000.00** | **-** |
| 210304 | Түрээсийн зардал | 13,716,000.00 | - |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **18,858,380.83** | **803,101.77** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,264,954.81 | 127,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 4,188,181.82 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,427,343.30 | 378,501.77 |
| 210404 | Ном хэвлэл | 2,904,071.81 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,073,829.09 | 297,000.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **4,307,300.00** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,307,300.00 | - |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал** | **257,458,240.79** | **-** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал | 556,363.64 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 45,360,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 210,898,295.09 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 643,582.06 | - |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **540,946,582.34** | **145,720,447.23** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 530,934,252.14 | 137,240,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | 10,012,330.20 | 8,480,447.23 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **13,077,998,012.56** | **4,006,957,370.75** |
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО** | **665,181,402.75** | **47,666,124.85** |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз | 665,181,402.75 | 47,666,124.85 |
| 5 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ** | **10,140,781,419.91** | **10,140,781,419.91** |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 10,140,781,419.91 | 26,137,672,171.69 |
| 225009 | Дамжуулан зээлдүүлэх зээл | - | 50,870,499.86 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө | - | 10,104,268.10 |
| 6 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | **3,602,397,995.40** | **(22,144,023,444.05)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөр дуусвар болсон хаалтын тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **3,355,594,193.15** | **-** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,355,594,193.15** | **-** |
| 120 | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **3,354,694,193.15** | **-** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 43,761,250.00 | - |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 3,310,932,943.15 | - |
| 120009 | Бусад орлого | 900,000.00 | - |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,087,636,339.09** | **224,284,080.17** |
| 210 | **Бараа, ажил үйлчилгээний бусад зардал** | **1,087,636,339.09** | **224,284,080.17** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **344,767,350.00** | **224,284,080.17** |
| 210101 | Үндсэн цалин | 344,767,350.00 | 2,122,650.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **43,361,250.00** | **-** |
| 210201 | Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал | 43,361,250.00 | - |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **14,931,109.02** | **803,101.77** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,264,954.81 | 127,600.00 |
| 210402 | Тээвэр шатахууны зардал | 2,988,181.82 | - |
| 210403 | Шуудан ,холбоо, интернэтийн төлбөр | 5,427,343.30 | 378,501.77 |
| 210404 | Ном, хэвлэл | 176,800.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс | 3,073,829.09 | 297,000.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **4,307,300.00** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,307,300.00 | - |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал** | **179,186,241.06** | **221,358,328.40** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 137,000,000.00 |
| 210802 | Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 22,635,000.00 | 25,650,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 556,363.64 | 240,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 152,624,023.55 | 58,468,328.40 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 643,582.06 | - |
| 210809 | Зар сурталчилгааны зардал | 2,727,271.81 | - |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **505,390,389.01** | **-** |
| 210901 | Сургалт, семинарын зардал | 505,390,389.01 | - |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,927,062.00** | **-** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | 3,927,062.00 | - |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **2,259,723,492.06** | **(224,284,080.17)** |
| 4 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз | 665,181,402.75 | 47,860,183.60 |
| 232001 | Гадаад төслийн зээлээс санхүүжүүлэх | 4,194,118,355.58 | 3,071,110,289.41 |
| 5 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(3,528,936,952.83)** | **(3,023,250,105.81)** |
| 6 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(1,269,213,460.77)** | **(3,247,534,185.98)** |
| 7 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **4,516,747,646.75** | **3,247,534,185.98** |
| 8 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **3,247,534,185.98** | **-** |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөр дуусвар болсон хаалтын тайлан*

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **18,541,625,448.65** | **18,541,625,448.65** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **18,541,625,448.65** | **18,541,625,448.65** |
| Тайлант үеийн үр дүн | 3,602,397,995.40 | 3,602,397,995.40 |
| **2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **22,144,023,444.05** | **22,144,023,444.05** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | **-** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **22,144,023,444.05** | **22,144,023,444.05** |
| Тайлант үеийн үр дүн | (22,144,023,444.05) | (22,144,023,444.05) |
| **2023 оны 10-р сарын 30-аарх үлдэгдэл** | **-** | **-** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөр дуусвар болсон хаалтын тайлан*

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **7,448,900,000.00** | **7,398,004,789.48** | **50,895,210.52** | **99.3** |
| **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **7,448,900,000.00** | **7,398,004,789.48** | **50,895,210.52** | **99.3** |
| Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл | 7,448,900,000.00 | 7,398,004,789.48 | 50,895,210.52 | 99.3 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **7,448,900,000.00** | **4,360,763,917.17** | **3,088,136,082.83** | **57.8** |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **7,448,900,000.00** | **4,360,763,917.17** | **3,088,136,082.83** | **57.8** |
| Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 7,448,900,000.00 | 4,360,763,917.17 | 3,088,136,082.83 | 55.8 |
| Тохируулсан орлогын дүн | | (210,293,313.67) | | |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 3,247,534,185.98 | | |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - | | |
| Төсвийн бусад мэдээлэл | | | | |
| Байгууллагын тоо | 1 | 1 | | 100.0 |
| Ажиллагсдын тоо | 7 | 3 | | 42.9 |
| Удирдах ажилтан | 1 | 1 | | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 6 | 2 | | 33.3 |

**Гурав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | ТШЗ | | | | | | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | 1 | 1 | | | 1 | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| **НИЙТ** | | **1** | **1** | | | **1** | | | |